УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2026 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч стратегийн, гамшгийн болон орон нутгийн нөөцийн бэлэн байдлыг сайжруулах, улсын болон орон нутгийн нөөцийн удирдлага, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хуулийн хэрэгжилт болон гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэл, бэрхшээл түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төсөлд орон нутгийн нөөцийн эрх зүйн зохицуулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоо, улсын нөөцийн агуулахын ашиглалт, гамшгийн үед хариу арга хэмжээ авах шуурхай удирдлага, цахим мэдээллийн нэгдсэн сан байгуулах талаар тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим хаягт байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага нь хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн санхүү, бараа, материалын нөөцийг бүрдүүлж, бие даан захиран зарцуулах эрхтэй эсэх, улсын нөөцийн санхүүжилтийг улсын төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир зарим улсад геополитикийн өнөөгийн нөхцөл байдлын улмаас иргэддээ онцгой байдлын үед хэрэглэх нөөц бүрдүүлэхийг зөвлөж байгаатай холбоотойгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, мэдээллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төсөлд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хүрээнд гаргах шийдвэр нь холбогдох хууль тогтоомжтой нийцэх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан хуулийн төслийн уялдаа холбоог хангах, улсын төсвийн орлого, зарлага болон нийгэм, эдийн засагт гарах өөрчлөлтийн бодит нөлөөллийг тооцоолон үр дүнгийн хэмжих нэгжийг тодорхой болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төсөлд аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн удирдлага өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналт тавих, удирдлагаар хангах эрхийг өөрчилсөн талаар,

мөн улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан Монгол Улсын усны нөөцийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа ус, цаг уурын өөрчлөлт, байгалийн аюулт үзэгдэл нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд орон нутагт эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хяналт шалгалтын зохицуулалтыг уян хатан болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр усны нөөц, ус ашиглалттай холбоотой сонсгол зохион байгуулах талаар санал хэлсэн болно.

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 57.9 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ **Д.ЦОГТБААТАР**